



ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ



ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВ



World Health
Organization
Mongolia

УЛИРЛЫН ТОМУУГИЙН ДЭГДЭЛТИЙН ҮЕД ХЭРЭГЖҮҮЛСЭН НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН

Зорилго

Сонгогдсон аймаг, дүүргийн хэмжээнд улирлын томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед хэрэгжүүлсэн нийгмийн эрүүл мэндийн хариу арга хэмжээг үнэлж, хариу арга хэмжээний чадавх, тулгарсан бэрхшээлийг тодорхойлж, цаашид сайжруулах, бэхжүүлэх.

Зорилт

- Дэгдэлтийн үед хэрэгжүүлсэн хариу арга хэмжээний бэрхшээлтэй болон сайн талыг тодорхойлох
- Дэгдэлтийн үед хэрэгжүүлсэн нийгмийн эрүүл мэндийн хариу арга хэмжээний сайн туршлагыг салбар болон салбар хоорондын мэргэжилтнүүдэд түгээх, туршлага солилцох
- Одоогийн ТТӨ-ий тандалтын тогтолцоог сайжруулах, бэхжүүлэхэд шаардлагатай цаашдын үйл ажиллагааны зөвлөмж гаргах.



Үнэлгээнд оролцогсад, хамрах хүрээ

ЭМГ, ЭМТ, БОЭТ, НЭ, ӨЭМТ-ийн эмч, ажилтан, ЗДТГ, ОБГ, ЦГ, ТГ, БШУГ, МХГ-ийн эрүүл мэндийн асуудал хариусан 127 мэргэжилтэн.

- 4 дүүрэг – 33
- Баян-Өлгий – 29
- Орхон – 24
- Төв – 11
- Говь-Алтай – 30

Үнэлгээний аргачлал

1. ДЭМБ, 2019 он “Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын дараах хариу арга хэмжээг үнэлэх үнэлгээний аргачлал”
2. Олон улсын эрүүл мэндийн дүрэм (2015)-ийн “Хяналт, үнэлгээний тогтолцоо”



Чиглэл	Үйл ажиллагаа
Тандалт, судалгаа	<ul style="list-style-type: none"> • Тандалт - дэгдэлтийг эрт илрүүлэх • Дэгдэлтийг эрт илрүүлэх үзүүлэлтийг зөв тооцсон байдал • Тандалтын мэдээллийн тогтолцоо • Хавьтлын тандалт судалгаа
Лаборатори	<ul style="list-style-type: none"> • Шинжилгээний хүчин чадал • Сорьц хадгалах, тээвэрлэх чадавч • Лабораторийн мэдээллийн тогтолцоо
Салбар, салбар хоорондын хамтын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> • Бүх түвшинд хэрэгжүүлсэн хариу арга хэмжээний уялдаа холбоо • Хариу арга хэмжээг зохион байгуулахад салбар хоорондын хамтын үйл ажиллагааг уялдуулсан байдал • Бэлэн байдлын төлөвлөгөө • Тохиолдлын удирдлагын тогтолцооны бүтэц, үйл ажиллагаа • Шуурхай удирдлагын нэгжийн үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалт • Шуурхай хариу арга хэмжээний багийн бүтэц, үйл ажиллагаа • Олон нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулах чадавч, бүтэц, зохион байгуулалт • Санхүүгийн шуурхай зохион байгуулалт
Эрсдлийн үеийн харилцаа холбоо	<ul style="list-style-type: none"> • Олон нийтэд мэдээлэл түгээх • Олон нийтийг татан оролцуулах байдал
Эмнэлзүйн тусламж үйлчилгээний зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> • Тохиолдлын менежмент • Халдварын сэргийлэлт хяналтын арга хэмжээ • Тусгаарлалт • Дархлаажуулалт • Халдвартай өвчтөнг оршуулах

1. Гүйцэтгэсэн үйл ажиллагаа
2. Тулгарч буй бэрхшээл
3. Цаашид сайжруулах, зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагаа

Үнэлгээний асуумж

Дараах 5 чиглэлийн хүрээнд 35 асуултаас бүрдэнэ.

- Тандалт, судалгаа
- Лаборатори
- Эмнэлзүйн менежмент
- Салбар хоорондын хамтын ажиллагаа
- Эрсдэлийн харилцаа холбоо

ТТӨ-ий дэдгалттай үед хэрэгжүүлсэн нийгмийн эрүүл мэндийн хариу арга хэмжээг үнэлэх асуумж (ЭМГ-ын ажил)	
Асуумж	
1.	Тандалт, судалгаа
1	ТГӨ-ий тасалганы тогтолцооны үйл ажиллагаа нэгдсэн үү?
2	Тасалганы тогтолцооны тогтвортой үйл ажиллагааг хангах, дэдгалттай эрт илрүүлэхэд бэлтгэгдсэн хүчийг нэмж, өөрчлөх эрмэлзлийг хэрэглэж, урвалыг зохицуулж гэгэ мэт нөхцөлд хангалттай байсан уу?
3	Тасалганы мэдээлэл цуглуулах, хадгалгах дүн шинжилгээг хийхэд бэлтгэгдэж үйл байсан уу?
4	ТГӨ-ий дэдгалттай эхлэхэд илрүүлсэн бэ? Дэдгалттай эрт илрүүлж чадсан үү?
5	Дэдгалттай эрт илрүүлэхэд төвлөрсөн хүчин рүүг, түүний зориу болон бүт үйл.
6	Тасалганы мэдээлэл хариу дүн шинжилгээг зөвхөн бэ? Шинжилгээний дүнг нийгмийн эрүүл мэндийн хариу арга хэмжээг төлөвлөхөд ашигласан үү?
7	Томруулын тасалганы үйл ажиллагаанд бусад салбарын орлогоор ямар байсан, мэдээллийг хэрэглэж бэ, бэлтгэгдэж байсан?
8	Дэдгалттай үед нийгмийн мэдээлэл цуглуулах, мэдээ өгөх дамжих, ихсэх, оролцон тооцож хянахад зарим нь хариу арга хэмжээнд нөлөөлж байсан үү? Энэ нь тасалганы үйл ажиллагааны амжилтыг хамгаалж байсан үү?
9	ТГӨ-ийн дэдгалттай холбоотой асуудлыг үнэлжээ үү? Хэрэв тийм бол хэрхэн, хэдэн удаа, ямар бэрхшээлтэйгэйгээ эмсэн бэ? Эрсдэлийн үнэлгээнд суурилсан ямар хариу арга хэмжээ авч хэрэгжүүлсэн бэ?
10	Лаборатори
1	Вирус судалганы лаборатори нь томруулын вирус илрүүлэх шинжилгээг хийдэг үү? Хэрэв тийм бол шинжилгээг хэдэн удаа хийж, хэрхэн мэдээлж байсан бэ?
2	Дэдгалттай үед лабораторийн тасалганы үйл ажиллагааг хангах бэлтгэгдсэн хүчийг нэмж, өөрчлөх, өсгөхөд дэдгалттай эхлэхэд хангалттай байсан үү?
3	Оршинд ямар тохиолдол, ямар шаардлагыг үндэслэн цуглуулдаг бэ? Дамтамгай?
4	Дэдгалттай үед үнэмлэхүй болон буйрын лабораториор баталгаажилт хийж байсан үү?
5	Эрх болон сумын түвшинд сорьц цуглуулах материал хангалттай байсан үү?
6	Түргэлтээр сорьцгүйг ашигладаг үү? Хэрэв тийм бол ямар тохиолдолд, эргэлтээр бэ?
7	Тохиу, тохиу төст вирус илрүүлэх шинжилгээний стандарт ажиллагааны заавар байгаа уу?
8	Сорьц цуглуулах, хадгалгах, тасаргахад ямар нэг бэрхшээл тулгарч байсан үү?
9	Ямар нэг бие-всрүүгээр бэлдсэн сорьц, долоолгоо гарч байсан үү? Хэрэв тийм бол шалтгааныг тайлбарлана уу.
10	Эмнэлзүйн менежмент

1	Дэдгалттай үеийн эмнэлзүйн тусламж үйлчилгээний болон бэлдэх төлөвлөгөөтэй юу? Үүнд орны соёл, уламжлалт үзэл, амьжиргаа, төсөг төлөвлөгөө, хүний нөөц, асуу цагийг шийдвэрлэх талаар тусалсан үү?
2	Дэдгалттай үед эмнэлзүйн тусламж үйлчилгээнд нэн шаардлагатай төсөг төлөвлөгөө, эм, эмнэлгийн хэрэгсэл, хүний нөөц хангалттай байсан үү? Тусламж байсан бэрхшээлд?
3	Эмнэлзүйн тусламж үйлчилгээний санхүүжилтийг хэрхэн зохион байгуулж байсан бэ?
4	Эрүүл мэндийн ажилтан, өвчтөн, үйлдүүлэгчид болон эмнэлгийн тусламж үйлчилгээнд ХСХ-ын чиглэлээр ямар арга хэмжээг хэрэгжүүлсэн бэ? Үнэмлэхүйгээр хэрэгжүүлсэн үү?
5	Эрүүл мэндийн байгууллагын ажилтай хөгжлийг хэрхэн зохион байгуулсан бэ? Хашааны үйлчилгээ бэлдэх, хамгаалах хувиар хэрэгсэл хэрэг нь хангалттай байсан үү?
6	Эрүүл мэндийн байгууллагын ажилтай хэрхэн зохион байгуулсан бэ?
7	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрүүл мэндийн хариу арга хэмжээг хэрхэн зохион байгуулж байсан бэ?
8	Дэдгалттай үеийн хариу арга хэмжээнд бусад салбарын орлогоор ямар байсан бэ?
9	Дэдгалттай үед зарим байгаа болон байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөө нь хэр үр дүнтэй байсан бэ?
10	Дэдгалттай үеийн нийгмийн эрүүл мэндийн хариу арга хэмжээг зохион байгуулахад санхүүжилт оролцож байсан үү? Орны улсын болон дотоодын хэмжээний байгууллагуудад дамжлагыг өссөн үү?
11	Эрүүл мэндийн байгууллагын эм, зарим эмчид дэдгалттай үед эмнэлзүйн өмчлөлтүүдэд сургалт өссөн үү?
12	Орны салбарын, оршинд хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулсан үү? Хэрэв тийм бол хариу арга хэмжээний хэрэгсэлтэнд хэрхэн нөлөөлж бэ?
13	Бэлэн байдал хариу арга хэмжээний төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг зохион байгуулж чадсан үү?
14	Эрсдэлийн харилцаа холбоо
1	Эрсдэлийн үеийн харилцаа холбооны байгуулж байсан бэ? Орон нутгийн эмнэлгийн харилцаа холбооны стратегийг байгуулж байсан үү?
2	Эрсдэлийн үеийн харилцаа холбооны асуудлыг хариуцаан турши мэдээлэл хийж байсан үү?
3	Дэдгалттай үед ямар ямаргаад мэдээллийг хэрхэн туршид байсан бэ? Эрсдэлийн харилцаа холбооны мэдээллийг хэрхэн туршид байсан үү?
4	Эрсдэлийн үеийн харилцаа холбооны мэдээллийг хэрхэн туршид байсан үү?
5	Дэдгалттай үед хүч ажил дүнд гарч байгаа өсгөр, буруу мэдээллийг хэрхэн шийдвэрлэж байсан бэ?

Ерөнхий зохион байгуулалт

Зохион байгуулсан хугацаа: 2022 оны 9 дүгээр сар

Зохион байгуулсан хэлбэр: Бүлгийн ярилцлага – 2 бүлэгт хуваасан, нэг бүлгийн ярилцлага 1 цаг 30 минут үргэлжилсэн

1. ЗДТГ, ОБГ, ЦГ, ТГ, БШУГ, МХГ-ийн эрүүл мэндийн асуудал хариусан мэргэжилтэн
2. ЭМГ, ЭМТ, БОЭТ, НЭ, ӨЭМТ-ийн эмч, ажилтан



Тандалт, судалгаа – Гүйцэтгэсэн үйл ажиллагаа

1. Тандалтын тогтолцооны үйл ажиллагаа жигдэрсэн. Мэдээ өгөх, цуглуулах, нэгтгэх, дүн шинжилгээ урсгал зохион байгуулалт бүрдсэн, үйл ажиллагаа тогтворжсон.
2. ТТӨ, АЗЦХХ-ын тандалтын мэдээг ихэвчлэн ЭМГ, НЭ 7 хоногоор нэгтгэн, дүн шинжилгээ хийж, НЭМ-ийн хариу арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэхэд ашигладаг.
3. 7 хоног бүр аймгийн бүх агентлагуудын дарга нарыг хамруулсан Шуурхай хурал дээр ЭМГ-аас ТТӨ, АЗЦХХ-ын ерөнхий өвчлөлийн байдлыг танилцуулж, цаашид анхаарах асуудлуудын талаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлдэг.
4. ОБГ, ЦГ, МХГ, БШУГ-т ТТӨ-ий дэгдэлтийн үед 7 хоног тутмын эргэн мэдээллийг цахимаар хүргүүлж, шаардлагатай бол хариу арга хэмжээг хамтран зохион байгуулдаг.
5. ДЭМБ-ын санхүүгийн дэмжлэгтэйгээр томуугийн тандалтын сорьцийг тээвэрлэх урсгал, зохион байгуулалтыг хялбар болсон.

Тандалт, судалгаа – Тулгарч буй бэрхшээл

1. Тандалтын мэдээг өгч хэвшсэн хэдий ч чанарын шаардлага хангахгүй. Дутуу мэдээлэх, өвчлөлийг буруу түүх, шинэ, хуучин өвчлөлийг ялгахгүй байх зэрэг нийтлэг алдаа дутагдалтай.
2. Аймгийн ЭМГ-аас нэгжүүдийн ТТӨ-ий бүртгэл, мэдээлэл, мэдээний чанарт хяналт тавьдаггүй.
3. Тандалтын тогтолцоог хариуцсан тархвар судлагч, дүн бүртгэгч нэгж дээр дутагдалтай, ажлын ачаалал их, цалин бага зэрэг шалтгаанаас болоод хүний нөөц тогтворгүй.
4. Улирлын томуу, томуугийн цартахлын хүндрэлийн үнэлгээний ач холбогдол, шийдвэр гаргахад хэрхэн ашиглах талаарх ойлголт, мэдээлэл хомс
5. Томуу, томуу төст вирусийн вирус судлалын шинжилгээний урвалж оношлуур өртөг өндөртэй байдаг гэсэн шалтгаанаар байгууллагын төсөвт суулгадаггүй, төсөвт тусгаж оруулсан ч шийдвэрлэх түвшинд очоод хасагдчихдаг.
6. Сорьцын материал авах, сорьц тээвэрлэх зардлын санхүүжилт тодорхойгүйн улмаас вирус судлалын тандалтыг тогтмол хийх боломжгүй.
7. Тандалт болон лабораторийн эмч нар уялдаа холбоо муутай. Мэдээлэл солилцдоггүй.

Тандалт, судалгаа – Цаашид сайжруулах үйл ажиллагаа

1. Тоон мэдээний чанарыг сайжруулах, түүнд тавих хяналтыг идэвхжүүлэх, тогтмол хийх.
2. Хүний нөөцийг бодлогоор бэлтгэх, ажлын байрны тогтвортой байдлыг хангах, тасралтгүй сургах.
3. Тандалтын тогтолцооны тогтвортой санхүүжилтийг бий болгох. Сорьц авах материал, урвалж оношлуур, сорьц тээвэрлэх зардлыг онцгойлон анхаарах.
4. Улирлын томуу, томуугийн цартахлын хүндрэлийн үнэлгээний аргачлалын талаар дахин сургалт зохион байгуулах. Улаанбаатар хот болон 5 аймгуудын босго үзүүлэлтийг тогтоох, 5 аймгийн үзүүлэлтийг шинэчлэх.
5. Сумын ЭМТ-үүдэд дэмжлэгт хяналт хийх, удирдлага, мэргэжилтнүүдэд тандалтын мэдээллийг шийдвэр гаргахад хэрхэн ашиглах талаар сургалт хийх.
6. Хилийн боомт бүхий аймгуудад жилийн турш ТТӨ-ий тандалт хийх нөхцөлийг бүрдүүлэх, хил залгаа улс орнуудын өвчлөлийн мэдээллийг тогтмол авч хариу арга хэмжээг төлөвлөж байх.

Лаборатори – Гүйцэтгэсэн үйл ажиллагаа

1. Молекул-биологийн лабораториуд нь томуугийн вирус судлалын шинжилгээ хийх чадавхитай тоног төхөөрөмж, хүний нөөц бэлтгэгдсэн.
2. Бүх лаборатори ТТӨ-ий шинжилгээний стандарт аюулгүй ажиллагааны зааварчилгаатай.
3. Сорьц авах тухай шийдвэрийг аймгийн ЭМГ-аас гаргадаг. Ингэхдээ ихэвчлэн НЭ-ийн дотор, хүүхдийн тасгаас сорьцоо цуглуулдаг.

Лаборатори – Тулгарч буй бэрхшээл

1. Молекул-биологийн лабораторид хүний нөөц бэлтгэгдсэн хэдий ажлын ачаалал нэмэгдэх үед хүрэлцэхгүй болдог.
2. Байгууллагын санхүүжилтэнд шинжилгээний урвалж оношлуур өртөг өндөр, тендерийн захиалганд байхгүй гэсэн шалтгаанаар оруулдаггүй. Иймээс томуугийн вирус судлалын шинжилгээг хийхгүй байгаа.
3. Сорьц тээвэрлэх зардлын санхүүжилт тодорхой бус.
4. Түргэвчилсэн оношлуурын нөөц, санхүүжилт байхгүй.
5. Салбар лаборатори нь вирус судлалын шинжилгээний дүнд баталгаажилт хийлгэдэггүй.

Лаборатори – Цаашид сайжруулах үйл ажиллагаа

1. Урвалж оношлуур, лабораторийн хэрэгсэл, сорьц авах материалын үнийг судалж, цаашид төсөвт тусгах талаар судлах, шийдлийг гаргах.
2. Сорьцыг тодорхой давтамжтайгаар, бүх харуулдан тандалтын нэгжийг хамруулах байдлаар, жигд тоогоор, шалгуур үзүүлэлтийн дагуу цуглуулах.
3. Яаралтай үед SARS-CoV-2 болон томуу, томуу төст вирусийг ялган оношлох түргэвчилсэн оношлуурын нөөцийг бий болгох.
4. Ажлын байрны сургалтыг тасарлтгүй зохион байгуулах.

Эмнэлзүйн менежмент - Гүйцэтгэсэн үйл ажиллагаа

1. Эмнэлэгт томүүгийн улирал угтуулан ор дэлгэх, эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх, хүний нөөцийг бэлтгэх төлөвлөгөө боловсруулж, нэмэлтээр дайчлан ажиллуулах эмч нарын хуваарийг гаргадаг.
2. КОВИД-19 цартахалтай холбоотой НЭ-ийн Хүүхдийн тасаг нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдсан.
3. ХСХ-ын стандарт сэргийлэлтийн арга хэмжээг нийт үйлчлүүлэгсэд, сахиурын дунд эрчимжүүлэн ажилладаг.
4. Ариутгал, халдваргүйтгэл, аюултай хог хаягдлыг устгах үйл ажиллагааг холбогдох тушаал, журмыг баримтлан зохион байгуулдаг.
5. Томүүгийн эмнэлзүй, эмчилгээний чиглэлээр эмч нарыг цахим сургалтанд хамруулсан.
6. Эрүүл мэндийн ажилтан нарын дунд шинж тэмдэгийн идэвхтэй тандалт хийж, ХСХ-ын арга хэмжээг чанд баримтлан ажиллахыг зөвлөдөг.

Эмнэлзүйн менежмент – Тулгарч буй бэрхшээл

1. Хүний нөөц дутмаг, ялангуяа хүүхдийн эмч, сувилагч хүрэлцдэггүй, ачаалал ихтэй байдаг.
2. НЭ-ийн хүүхдийн тасаг шаардлагатай тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан хэдий ч дэгдэлтийн үед хүрэлцдэггүй.
3. Өрх, сум, тосгоны ЭМТ, НЭ-т вирусийн эсрэг эм, антибиотикийн нөөц хангалтгүй, зарим тохиолдолд тасалддаг.
4. Тендэрээр нийлүүлж байгаа аюултай хог хаягдлын уут, хайрцаг чанар, стандартын шаардлага хангадаггүй.
5. Зарим вирусийн эсрэг эм, антибиотик өртөг өндөртэй, ЭМД-ын хөнгөлөлттэй эмийн жагсаалтад хангалттай байдаггүй.
6. Өрхийн эрүүл мэндийн төв дээр нэн шаардлагатай зарим тоног төхөөрөмж дутмаг.

Эмнэлзүйн менежмент – Цаашид сайжруулах үйл ажиллагаа

1. Эмнэлгийн орны төлөвлөлтийг хийхдээ хүний нөөц, эм, эмнэлгийн хэрэгслийг давхар тооцон, төлөвлөх.
2. НЭ-ийн хүүхдийн тасагт томуугийн дэгдэлтийн үед шаардлагатай тоног төхөөрөмжийн тоог нэмэгдүүлэх.
3. НЭ, ӨЭМТ-д вирусийн эсрэг эм, антибиотикийн нөөцийг өвчлөлийн байдалтай уялдуулан бүрдүүлэх.
4. Дэгдэлтийн үед ялган оношилгоо хийхэд ашиглах түргэвчилсэн оношлуурын нөөцтэй болох.

Салбарын дотоод болон салбар хоорондын хамтын ажиллагаа - Гүйцэтгэсэн үйл ажиллагаа

1. Гамшгаас хамгаалах төлөвлөгөө, Шадар сайдын А/08 тушаалын дагуу салбар хоорондын хамтын ажиллагааг зохион байгуулдаг.
2. КОВИД-19 цартахлын үед УОК-оос нэгдсэн удирдлагаар хангаж байсан учраас салбар хоорондын хамтын үйл ажиллагааг зохион байгуулахад хялбар байсан.
3. Аймгийн засаг даргын тушаалаар салбар хоорондын мэргэжилтнүүдийг оролцуулсан ажлын хэсэг байгуулагдан дэгдэлтийн үед хамтран хариу арга хэмжээг төлөвлөн ажилладаг.
4. Аймгийн ЭМГ-аас жил бүр “ТТӨ-ий дэгдэлтийн үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөө”-г боловсруулан харьяа Өрх, Сумын ЭМТ, НЭ-т хүргүүлж, бэлэн байдлыг хангуулдаг.

Салбарын дотоод болон салбар хоорондын хамтын ажиллагаа - Гүйцэтгэсэн үйл ажиллагаа

1. ЭМГ-аас өвчлөлийн нөхцөл байдалтай уялдуулан орны бэлэн байдлыг хангах, эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуурын нөөцийг бэлтгэх, тасралтгүй байдлыг хангах чиглэлээр зөвлөмж бэлтгэн НЭ, өрх, сумын ЭМТ-д хүргүүлдэг.
2. БШУГ-т ЭМГ-аас хичээл сургалтын үйл ажиллагаа эхлэхтэй холбогдуулан сургууль, цэцэрлэг хүүхдийн байгууллагад халдвар хамгааллын дэглэмийг баримтлахад шаардлагатай зүйлсийг бэлтгэх, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах чиглэлээр зөвлөмж хүргүүлж, түүний дагуу БШУГ-аас холбогдох арга хэмжээг зохион байгуулж ажилладаг.
3. МХГ нь өвчлөл нэмэгдэх үед сургууль, цэцэрлэгээр дэмжлэгт хяналт хийж, цахимаар зөвлөгөө өгдөг.
4. ЭМГ, ӨЭМТ-үүд харъяа сургууль, цэцэрлэгийн эмч нартай хамтран ажиллаж ирцийн тандалт хийх, эрүүл мэндийн үзлэг зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг зохион байгуулдаг.

Салбарын дотоод болон салбар хоорондын хамтын ажиллагаа – Тулгарч буй бэрхшээл

1. Олон салбарын хамтын ажиллагааг зохицуулсан нарийвчилсан зааварчилгаа байхгүй.
2. Салбаруудын үүрэг, гүйцэтгэх үйл ажиллагааг зохицуулсан журам байхгүй, салбар хоорондын уялдааг хангахад ачаалал ихтэй байсан.
3. Дэгдэлтийн үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан ажилладаг хэдий ч тухайн жилд хэрэгжүүлсэн төлөвлөгөөнд үнэлгээ дүгнэлт хийдэггүй, зарим үйл ажиллагаа төлөвлөгөөний дагуу хийгдээгүй.

Салбарын дотоод болон салбар хоорондын хамтын ажиллагаа - Цаашид сайжруулах үйл ажиллагаа

1. Салбаруудын холбогдох тушаал зааврыг уялдуулсан, олон салбарыг оролцуулсан хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах. Хэн, хаана, хэзээ оролцох талаар нарийвчлан тусгах
2. Өмнөх томуугийн улиралд хэрэгжүүлсэн бэлэн байдал хариу арга хэмжээний төлөвлөгөөнд эргэмж үнэлгээ хийж, дараагийн ажлын төлөвлөгөөг гаргах.

Эрсдэлийн харилцаа - Гүйцэтгэсэн гол үйл ажиллагаа

1. Байгууллага бүр эрсдэлийн харилцааны мэргэжилтэн эсвэл багтай.
2. Эрсдэлийн үнэлгээ, өвчлөлийн тархалтын үе шатанд суурилан эрсдэлийн харилцааг идэвхжүүлдэг.
3. Олон нийтэд зориулсан зөвлөмж, зөвлөгөөг орон нутгийн томоохон фэйсбүүк хуудас болон байгууллагын цахим хуудсаар дамжуулан хүргэдэг.
4. ЭМГ-аас сургалт сурталчилгааны багийг НЭ, ӨЭМТ, ЭМГ-ийн эмч нарын оролцоотойгоор байгуулж, төлөвлөгөө батлуулан ажилладаг.
5. КОВИД-19-ийн дархлаажуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор явлуулын сурталчилгааны баг, дархлаажуулалтын баг ажилласан, албан байгууллагыг татан оролцуулсан.
6. ЦГ-аас сөрөг мэдээллийг тухай бүрт тодруулж, шаардлагатай арга хэмжээг авдаг.
7. БШУГ ЭМГ-тай хамтран сургууль, цэцэрлэг хүүхдийн байгууллагын эрхлэгч, удирдлагууд, эмч нарт сургалт явуулдаг.
8. Орон нутгийн томоохон зах, худалдааны төв, зочид буудал зэрэгт улирал угтуулан бэлэн байдлыг хангах талар мэдээлэл хүргүүлж, сургалт сурталчилгаа хийдэг.

Эрсдэлийн харилцаа - Тулгарч буй бэрхшээл

1. Ажлын байрны тогтвортой байдал хангалтгүй, бэлтгэгдсэн мэргэжилтэн байнга солигддог.
2. Орон нутгийн онцлогоос хамаарч сургалтыг тухай бүрт зохион байгуулж чаддаггүй.

Эрсдэлийн харилцаа - Цаашид сайжруулах үйл ажиллагаа

1. Тасралтгүй сургалт зохион байгуулах, мэргэжилтнүүдийг чадавхжуулах.
2. Мэдээллийг шинжлэх ухааны үдэслэлтэйгээр бэлтгэж, нэг сувгаар хүргэх.
3. Эрсдэлийн харилцааны олон салбарыг оролцуулсан нэгдсэн төлөвлөгөө, журам гаргаж ажиллах.

Дүгнэлт, санал:

1. ТТӨ, АЗЦХХ-ын тандалтын үйл ажиллагаа жигдэрсэн хэдий ч, тандалтын мэдээний чанар хангалтгүй, хүний нөөц тогтворгүй, мэдээ цуглуулах аргачлал нэгж тус бүр дээр ялгаатай байна.
2. НЭМ-ийн хариу арга хэмжээг төлөвлөн, хэрэгжүүлдэг хэдий ч ТТӨ-ий өвчлөлийн тархалтын түвшинг үндэслэл болгодоггүй байна. Цаашид улирлын томуу, томуугийн цартахлын хүндрэлийн үнэлгээний дүнг шийдвэр гаргахад ашиглах, энэ чиглэлээр сургалт хийх.
3. Нэгжүүд дээр хүний нөөц хангалтгүй, ажлын ачаалал их, байнга өөрчлөгдөж байгаа нь тандалтын тогтолцооны тогтвортой байдалд нөлөөлж байна. Иймээс хүний нөөцийг бодлогоор бэлтгэх, тасралтгүй сургах шаардлагатай байна.
4. Байгууллагын төсөвт шинжилгээний урвалж оношлуур, сорьцийн материал авах, тээвэрлэх зэрэг зардал тусгагдаагүй, санхүүжилт тодорхойгүй байна. Цаашид санхүүжилтийг хэрхэн шийдвэрлэх талаар судлах, шийдлийг олох.

6. Томуугийн улирал угтуулан орны зохицуулалт хийх, эмийн нөөц, тоног төхөөрөмж, хүний нөөцийн бэлэн байдлыг хангах чиглэлээр төлөвлөгөө боловсруулан ажилладаг хэдий ч, нэмэлтээр ор дэлгэх бол түүнийг дагаад гарах нөөц, хангамжийн асуудлыг урьдчилан тооцоолох.
7. Зарим бодлогын түвшинд гарч байгаа баримт бичиг бодит байдалд нийцдэггүй, ямарваа нэгэн түр журам, заавар, тушаал шийдвэр гаргахдаа салбарын хүмүүст танилцуулж, саналыг авах, хамтын уялдаатай шийдвэрлэх.
8. Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний чиглэлээр холбогдох тушаал зааврыг уялдуулсан, олон салбарыг оролцуулсан нийгмийн эрүүл мэндийн хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах.

**АНХААРАЛ ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА**